

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн захиргааны зөвлөлийн 2013 оны 9 дүгээр сарын 18-ний өдрийн хурлаар хэлэлцэн батлав

МУИС-ИЙН ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛИЙН ТӨГСӨЛТИЙН НЭГДСЭН ШАЛГАЛТЫН ЖУРАМ

НЭГ. ЕРӨНХИЙ ҮНДЭСЛЭЛ

1.1. МУИС-ийн Хууль зүйн сургуулийн оюутны төгсөлтийн нэгдсэн шалгалтыг (цаашид ТНШ гэнэ) Монгол Улсын БСШУ-ын сайдын баталсан “Дээд боловсролын төгсөлтийн шалгалтын үлгэрчилсэн журам”, МУИС-ийн захирлын 2013 оны 04 дүгээр сарын 25-ний өдрийн тоот тушаалаар батлагдсан “Нэгдсэн шалгалтын үлгэрчилсэн журам” болон энэхүү журмыг баримтлан авна.

1.2. МУИС-ийн Хууль зүйн сургуулийн оюутны ТНШ-ын журам нь дээр нэрлэсэн журмуудад нийцэж байхын зэрэгцээ хууль зүйн мэргэжлийн сургалтын үнэлгээний онцлогийг тусгасан байна.

1.3. Хууль зүйн сургуулийн оюутны ТНШ нь төгсөгчдийн онолын мэдлэг хийгээд хууль хэрэглэх, тайлбарлах, эрх зүйн шинжилгээ хийх, хууль зүйн туслалцаа үзүүлэх арга, чадварыг үнэлэхэд чиглэсэн байна.

ХОЁР. ТӨГСӨЛТИЙН НЭГДСЭН ШАЛГАЛТЫН ХЭЛБЭР, АГУУЛГА

2.1. ТНШ-ыг бичгээр авах бөгөөд онолын мэдлэгийн болон ур чадварын гэсэн 2 төрөлтэй.

2.2. Онолын мэдлэгийн шалгалт сонгох хувилбар бүхий сорилоос бүрдэнэ. Эрх зүйн хөтөлбөрөөр авах онолын мэдлэгийн шалгалтын агуулга нь Эрх зүй, төрийн онол, Үндсэн хуулийн эрх зүй, Үндсэн хуулийн процесс, Захиргааны эрх зүй, Захиргааны процесс, Иргэний эрх зүй, Иргэний процесс, Хөдөлмөрийн эрх зүй, Эрүүгийн эрх зүй, Эрүүгийн процесс, Эрүүгийн ял эдлүүлэх эрх зүйн судлагдахууны үндсэн ойлголт, зарчмуудыг хамарсан байна.

2.3. Олон улсын эрх зүйн хөтөлбөрийн онолын мэдлэгийн шалгалтын агуулга нь Эрх зүй, төрийн онол, Үндсэн хуулийн эрх зүй, Үндсэн хуулийн процесс, Олон улсын нийтийн болон хувийн эрх зүйн судлагдахууны үндсэн ойлголт, зарчмуудыг багтаасан байна. Англи хэл, хууль зүйн орчуулгын шалгалт онолын мэдлэг шалгах шалгалтын нэг үндсэн хэсэг байх бөгөөд үнэлгээг тусад нь гаргана.

2.4. Ур чадварын шалгалт нь хууль хэрэглэх, тайлбарлах, эрх зүйн шинжилгээ хийх, хууль зүйн туслалцаа үзүүлэх арга, чадварыг үнэлэхэд чиглэсэн хууль зүйн бодлого байна.

2.5. Эрх зүйн хөтөлбөрөөр авах ур чадварын шалгалтын агуулга нь онолын мэдлэгт тулгуурлан Үндсэн хууль, Захиргаа, Иргэн, Эрүүгийн эрх зүйн болон Үндсэн хуулийн, Иргэний, Захиргаа, Эрүүгийн эрх зүйн процессын бодлогыг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэхэд чиглэсэн байна.

2.6. Олон улсын эрх зүйн хөтөлбөрөөр авах чадварын шалгалт нь Олон улсын нийтийн эрх зүй, Олон улсын хувийн эрх зүй, Олон улсын эрүүгийн эрх зүй, Олон улсын гэрээний эрх зүй, Монгол Улсын Иргэний болон Эрүүгийн эрх зүйн бодлогыг Олон улсын гэрээ, Конвенц Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэхэд чиглэнэ.

ГУРАВ. ТӨГСӨЛТИЙН НЭГДСЭН ШАЛГАЛТЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

3.1. Төгсөлтийн нэгдсэн шалгалтын комиссыг (цаашид ТНШК гэнэ) мэргэжлийн тэнхим, профессорын багийн саналыг үндэслэн ХЗС-ийн захирлын тушаалаар томилно. Тус комисс нь ТНШ-ыг зохион байгуулна. ТНШК-ыг бакалаврын судалгааны ажил хамгаалуулах комисстой нэгтгэсэн нэг комисс байгуулж болно.

3.2. ТНШК-ыг эрх зүй болон олон улсын эрх зүйн хөтөлбөр тус бүрээр байгуулж болно.

3.3. ТНШК нь дарга, 5-7 гишүүд, нарийн бичгийн дарга нараас бүрдэнэ. Комиссын бүрэлдэхүүнд мэргэжлийн голлох профессор, тэнхимийн эрхлэгч, багш нарыг оруулахын зэрэгцээ тухайн хөтөлбөрийг эрхэлж байгаа тэнхим, профессорын багаас тусдаа ажилладаг МУИС-ийн бүрэлдэхүүний болон бусад эрдэм шинжилгээний байгууллагын ажилтан, эрдэмтэд, хамтран ажилладаг мэргэжлийн байгууллага, ажил олгогч байгууллагуудын төлөөллийг оруулж болно. ТНШК-ын дарга нь тус сургуулийн захирал байх бөгөөд түүний эзгүйд орлогч дарга, эсхүл томилогдсон аль нэг гишүүн удирдана. ТНШК-ын нарийн бичгийн даргаар сургалтын инженерийг томилон ажилуулж болно.

3.4. ТНШК-ын нарийн бичгийн дарга нэгдсэн шалгалтын протокол хөтлөх ба шалгалтын ерөнхий үйл явцыг тоймлон, шалгалтын явцад гарсан зөрчилтэй асуудлын талаар дэлгэрэнгүй бичнэ. Мөн нэгдсэн шалгалтанд хангалтгүй дүгнэгдсэн болон ороогүй оюутны шалгалт хойшилсон тухай тэмдэглэгээг заавал хийнэ.

3.5. ТНШ-ын сорил болон хууль зүйн бодлогыг боловсруулах, сан бүрдүүлэх ажлыг холбогдох тэнхим, профессорын баг эрхлэн гүйцэтгэнэ.

3.6. Тэнхимийн эрхлэгч, профессорын багийн ахлагч ТНШ-ын сорил болон хууль зүйн бодлогыг бэлэн болсон гэж үзвэл хянан, гарын үсэг зурж, дугтуйд хийж битүүмжлэн шалгалт эхлэхээс 24 цагийн өмнө Хууль зүйн сургуулийн Сургалтын албанд хүлээлгэн өгсөн байна.

3.7. Шалгалт эхлэх өдрийн өглөө урьдчилан тогтоосон цагт ТНШК-ын дарга гишүүдийнхээ гуравны хоёроос доошгүйг байлцуулан шалгалтын битүүмжилсэн санг биечлэн нээж, зохих нууцлалын дагуу сонгож, олшруулах зөвшөөрөл олгоно.

3.8. Тухайн шалгалтын сорил, хууль зүйн бодлогыг ТНШК-ын хоёр гишүүний хяналтын дор хаалттай нөхцөлд олшруулна.

ДӨРӨВ. ТӨГСӨЛТИЙН НЭГДСЭН ШАЛГАЛТ

4.1. ТНШ-ыг улирлын хугацаанд багтаан авах ба шалгалтын хуваарийг оюутны хамт олон болон мэргэжлийн тэнхим, профессорын багийн саналыг харгалзан Сургалтын албаны эрхлэгч баталж, шалгалт эхлэхээс 3-2 долоо хоногийн өмнө багш, оюутанд мэдээлж, мэдээллийн системд байрлуулсан байна.

4.2. ТНШК-ын гишүүдийн 2/3-оос доошгүй ирцтэй үед шалгалтыг авна. Комиссын гишүүдийн ирцийг комиссын нарийн бичгийн дарга ирсэн, явсан цагаар нь бүртгэнэ. Комиссын нарийн бичгийн даргад шалгалт үргэлжилсэн хугацаанаас хоёр цаг илүү тооцно.

4.3. ТНШ-нд хүндэтгэн үзэх шалтгааны (ар гэрийн гачигдал, хүндээр өвөдөх гэх мэт) улмаас хүрэлцэн ирээгүй, хоцорсон, эсвэл төгсөлтийн шалгалтанд хангалтгүй дүн үзүүлсэн бол дараагийн гурван жилд багтаан төгсөлтийн шалгалтын хуваарьт өдөр өгөх эрхтэй.

4.4. Шалгалт өгөх оюутны нэрсийн жагсаалтад хувийн болон хуваарьт ширээний дугаарыг бичсэн байна. Оюутан зөвхөн заасан суудалд сууна.

4.5. Оюутан бичгийн ажил дээр онцгой тэмдэг тавих, цаасыг нугалах, нэр бичих, өнгө хольж бичих, тусгай тэмдэглэгээтэй хууль ашиглах, өөр суудалд суух, сурах бичиг, гарын авлага, хуулийн албан ёсны болон шинжлэх ухааны тайлбар ашиглахыг хориглоно. Хориглосон заалтыг зөрчсөн оюутны бичгийн ажлыг хүчингүйд тооцно.

4.6. Онолын мэдлэг болон ур чадварыг шалгахдаа тус бүр 100 оноогоор, 9 баллын системээр үнэлэн дүгнэнэ. Онолын шалгалт авахдаа Сургалтын төв албанд хандан тестээр авч болно.

4.7. Онолын мэдлэгийн шалгалтыг энэ журмын 2.2 болон 2.3-т заасан хичээлүүдийн агуулгын хүрээнд 200 асуултаар нийт 200 минут авна. ТНШК-ын гишүүн болон оюутны дэргэд сорилын тусгай машинаар засна. Шалгуулагчдын авсан оноог нэгдсэн дүнгийн хуудсанд ТНШК-ын нарийн бичгийн дарга үнэн зөв бичнэ. Түүний үнэн зөв эсэхийг комиссын дарга, эсхүл түүний томилсон комиссын гишүүн машины эхтэй тулган шалгана. Шалгалтын онооны нэгдсэн хуудсанд комиссын дарга, нарийн бичгийн дарга, гишүүд гарын үсгээ тус тус зурна.

4.8. ТНШК-ын нарийн бичгийн дарга онолын шалгалт дууссанаас хойш ажлын гурав хоногт багтаан сургалтын мэдээллийн системэд оруулсан байна.

4.9. Онолын мэдлэгийн шалгалтад авбал зохих онооны 60 ба түүнээс дээш хувийг авсан оюутан ур чадварын шалгалтад орох эрхтэй. 60-аас доош хувьтай шалгагдсан оюутан хичээлийн гурван жилийн дотор хуваарьт өдөр нь дахин шалгалт өгч болно.

4.10. Чадварын шалгалт нь энэ журмын 2.5 болон 2.6-т заасан салбар эрх зүйг жигд хамрах бөгөөд нийт 4 хууль зүйн бодлого бодох байх ба үргэлжлэх хугацаа нийт 6 цаг (бодлого тус бүр 90 минут) байна.

4.11. Хууль зүйн бодлого шийдвэрлэхэд шаардлагатай хууль тогтоомжийг ТНШК бэлтгэсэн байна. Эдгээр хууль тогтоомжуудад ямар нэгэн тэмдэглэл хийсэн байж болохгүй. Шалгалт эхлэхийн өмнө шалгалтын комиссын гишүүд хуулиудыг нэгбүрчлэн шалгана.

4.12. Чадварын шалгалтын бичгийн ажлыг Хууль зүйн сургуулийн тэмдэг дарсан тусгай цаасан дээр гаргацтай, цэвэр нямбай, үсгийн дүрмийн хувьд зөв бичсэн байна. Энэ шаардлагыг хангаагүйн улмаас үүдсэн үнэлгээний маргааныг ТНШК авч хэлэлцэхгүй.

4.13. Бичгийн ажлыг хийж дууссаны дараа ТНШК-ын нарийн бичгийн дарга нэгдсэн журмаар нэгэн зэрэг хураан авна. Чадварын шалгалтын бичгийн ажилд оюутан өөрийн хувийн болон ширээний дугаарыг бичсэн тусгай хуудсыг хавсаргаж үдсэн байна.

4.14. Бичгийн ажлыг ТНШК-ын дарга, гишүүдийг байлцуулан нарийн бичгийн дарга шифрлэнэ. Шифрийг бичгийн ажил болон хувийн дугаар бүхий хуудсан дээр улаан балаар гурваас дээш оронтой тоогоор бичсэний дараа хувийн дугаар бүхий хуудсыг бичгийн ажлаас салган авч тусгай дугтуйд хийж ТНШК-ын дарга, нарийн бичгийн дарга дугтуйны нааж битүүмжилсэн хэсэгт гарын үсгээ тус тус зурж, Хууль зүйн сургуулийн тэмдгийг дарж, ТНШК-ын нарийн бичгийн дарга хадгална.

4.15. Чадварын шалгалтын бичгийн ажлыг холбогдох тэнхим, профессорын багаас томилогдсон шалгагч багш нар ажлын гурав хоногийн дотор багтаан шалгана. Бичгийн ажлыг ТНШК-ын нарийн бичгийн дарга хуваарилахдаа бичгийн ажлын шифрийн дугаараар сугалуулан оноож, хүлээлгэн өгнө. Бичгийн ажлыг засаж байгаа шалгагч багш бичгийн ажлыг зөвхөн Хууль зүйн сургууль дээр бэлтгэсэн газар засна. Бичгийн ажил засаж буй өрөөнд ТНШК-ын дарга, нарийн бичгийн даргаас өөр хүн орох, бичгийн ажлыг авч гарахыг хориглоно.

4.16. Бичгийн ажлыг шалгаж дууссаны дараа үнэлгээний оноо бодитой эсэхийг ТНШК-ын дарга, эсхүл түүний томилсон гишүүн шалгана. Үнэлгээний оноо бодитой байвал гарын үсгээ зурна. Хэрэв үнэлгээний оноо бодитой бус болон

саналын зөрүүтэй бол энэ тухай тэмдэглэл бичиж ТНШК-д танилцуулна. Комисс үүнийг үндэслэлтэй гэж үзвэл комиссын гурван гишүүнээр дахин шалгуулж оноог өөрчлөх эсэхийг эцэслэн шийдвэрлэнэ.

4.17. Бичгийн ажлыг дахин шалгасны дараа ТНШК-ын дарга битүүмжилсэн хувийн дугаар, шифр бүхий хуудсыг задалж, онооны нэгдсэн жагсаалтыг ТНШК-ын гишүүдийн гуравны хоёрын хяналт дор гаргаж, оюутны хувийн дугаараар тогтоосон хугацааны дотор ил тод мэдээлнэ.

4.18. Ур чадварын шалгалтанд 60-аас доош хувьтай шалгагдсан оюутан хичээлийн гурван жилийн дотор хуваарьт өдөр нь дахин шалгалт өгч болно.

4.19. Төгсөлтийн шалгалтын үйл ажиллагаанд тэнхим, профессорын баг, Сургалтын алба хяналт тавина.

4.20. ТНШК-ын нарийн бичгийн дарга ур чадварын шалгалт дууссанаас хойш ажлын гурав хоногт багтаан сургалтын мэдээллийн системэд оруулсан байна.

ТАВ. ШАЛГАЛТААС ҮҮДСЭН ЗӨРЧИЛ, МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ

5.1. Сорил, бодлогын агуулга, зохиомж болон шалгалтын үнэлгээтэй холбоотой маргаан, гомдлыг өргөдлийн дагуу ТНШК хамтын зарчмаар эцэслэн шийдвэрлэнэ.

5.2. Сорилгын болон бодлогын шалгалтын дотоод журам зөрчсөн тохиолдолд маргааныг газар дээр нь комисс томилж шийдвэрлэнэ.

5.3. Онолын мэдлэгийн шалгалттай холбоотой маргаан, гомдлыг дүн танилцуулснаас хойш 3 хоногийн дотор гаргах эрхтэй ба гомдлыг өдөрт нь багтаан шийдвэрлэнэ.

5.4. Хууль зүйн бодлогын үнэлгээ, агуулга, зохиомжийн талаархи маргаан, гомдлыг дүн танилцуулснаас хойш 3 хоногийн дотор гаргах эрхтэй ба гомдлыг ажлын хоёр хоногт багтаан шийдвэрлэнэ.

5.5. Журамд заасан хугацаа өнгөрсөн тохиолдолд өргөдөл хүлээж авахгүй.